



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д. Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2025.08.19 № 30

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР
ТАНАА

Монгол Улсын Засгийн газрын
тогтоолын хэрэгжилтийн талаар

Монгол Улсын Засгийн газраас төрийн албан хаагчдыг орон нутагт тогтвор, суурьшилтай ажиллах сонирхлыг нэмэгдүүлэх зорилгоор “Төрийн захиргааны, үйлчилгээний, болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох журам”-ыг Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралт, Засгийн газрын 2024 оны 82 дугаар тогтоолын хавсралтаар өөрчлөн баталж, нэмэгдлийг олгож байна.

Улсын Их Хурлын гишүүн миний бие дээрх журмын хэрэгжилттэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Танд дараах асуултыг тавьж байна. Үүнд:

1. “Төрийн захиргааны, үйлчилгээний, болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох журам”-ын 2.1 дэх хэсэгт “Орон нутагт ажилласны нэмэгдлийг хөдөөгийн сум (тосгон)-д ажиллаж байгаа төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид тухайн эрхэлж байгаа албан тушаалын үндсэн цалингийн 40 хувиар, аймгийн төв болон нийслэлийн алслагдсан Багануур, Багахангай, Налайх дүүрэгт ажиллаж байгаа төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид тухайн эрхэлж байгаа албан тушаалын үндсэн цалингийн 20 хувиар тус тус бодож, сар бүр олгоно.” гэж заасан байна. Эндээс үзэхэд нийслэлийн алслагдсан Багануур, Багахангай, Налайх дүүргийн төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагын багш, ажилтнуудад (сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалтан-ТҮБД, Мэргэжлийн болон, техникийн боловсролын сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалтан-ТҮМБ, төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалтан-ТҮ) үндсэн цалингийн 20 хувиар тооцон олгохоор байна. Гэвч тухайн дүүргүүдийн багш, ажилтнуудаас ирүүлсэн санал, гомдлоос үзэхэд тус нэмэгдлийг өнөөг хүртэл олгоогүй байна. Иймд энэхүү нэмэгдлийг олгохгүй байгаа шалтгаан, нөхцөлийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг;

2025000049

2. Багануур, Багахангай, Налайх дүүргийн төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллага, Насан туршийн суралцахуйн төвийн багш, ажилтнуудын орон нутгийн нэмэгдлийг 2025 оны 9 дүгээр сараас тооцон олгох боломжтой эсэх талаар;
3. Багануур, Багахангай, Налайх дүүргийн төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллага, Насан туршийн суралцахуйн төвийн багш, ажилтнуудын орон нутгийн нэмэгдлийг Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд хэрхэн тусгаж байгаа талаарх зэрэг болно.

Асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-т заасан хугацаанд бичгээр ирүүлэхийг хүсье.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



Ц.МӨНХТУЯА

2025000049